



2025 оны 03 дугаар сарын 27  
№14 (1359)

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
АЛБАН МЭДЭЭЛЭЛ



## **ГАРЧИГ**

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

69.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 139	631
70.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 140	657



## БҮХСАМ

СҮРҮҮЧ СҮХБАА ГУР ГИБСР ГУР ТАССОР ГУР ГИССИШТЭЭ

65

ХАНШН 656

65

ХАНШН 656

66.

БҮХСАА МИДСИСР ГИХССОУ ГИССЛ

65

ХАНШН 656

60.

БҮХСАА МИДСИСР ГИХССОУ ГИССЛ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Хүүхэд оролцож амжилт гаргасан тохиолдолд сангаас шагнал урамшуулалт олгох олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадмын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 172 дугаар тогтоол, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 120 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 139 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Хүүхдийн төлөө сан” (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавихад энэ журмыг баримтална.

1.2.Сангийн үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгоно.

### Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Сангийн удирдлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

2.2.Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

2.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1.хуульд заасан эх үүсвэр тус бүрээр Сангийн орлогыг төлөвлөх, түүнийг бүрдүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө, зарцуулалтын хуваарийг боловсруулж, батлуулан мөрдөх;

2.3.2.холбогдох хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын санхүүжилтээр дэмжих арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах, хяналт тавих;

2.3.3.энэ журамд заасан мөнгөн шагнал, дэмжлэгийг журамд заасны дагуу шийдвэрлүүлж, олгох;

2.3.4.Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаарх хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хандивын хөрөнгийг бүртгэх, ашиглах, хадгалах, Сангийн дансанд төвлөрүүлж, тогтвортой үйл ажиллагааг хангах;



2.3.5.хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах;

2.3.6.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, хандив, тусlamж, зарцуулалтын болон Сангаас санхүүжилт авсан төсөл, арга хэмжээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

2.3.7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад энэ журмын 2.3.6-д заасан мэдээллийг ил тод, нээлттэй олон нийтэд мэдээлэх;

2.3.8.баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих.

2.4.Мөнгөн бус хандив, тусlamжийн хөрөнгийг зохих журмын дагуу дуудлага худалдаагаар худалдах үйл ажиллагааг зохион байгуулж, орлогыг Санд төвлөрүүлнэ.

2.5.Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup>.4-т заасны дагуу автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогыг Санд төвлөрүүлж, хагас, бүтэн жил тутам “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газартай тооцоо нийлж, акт үйлдэнэ.

#### **Гурав.Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ**

3.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3-т заасан арга хэмжээг санхүүжүүлэхдээ зарцуулна.

3.2.Энэ журмын 3.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхдээ хүүхдэд хамгааллын үйлчилгээний болон төсвийн бусад байгууллагаас олгох санхүүжилттэй давхардуулан олгохгүй.

3.3.Төсвийн жил дамжин хэрэгжихээс бусад төсөл, арга хэмжээтэй холбогдуулж Сангаас санхүүжилт олгосон шийдвэр нь тухайн төсвийн жилдээ хүчинтэй байна.

#### **Дөрөв.Сангийн хөрөнгийн санхүүжилтээр хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжих**

4.1.Сангийн хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнахтай холбогдох харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлж энэ журам болон Засгийн газраас баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг баримтлан хэрэгжүүлнэ.

4.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3.1-д заасан дэмжлэгийг дараах чиглэлээр үзүүлнэ:

4.2.1. хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих;

4.2.2. хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;

4.2.3. хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах.

4.3. Энэ журмын 4.2.1, 4.2.2-т заасан төсөл, арга хэмжээний санал нь Засгийн газраас баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.3.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3.1-д заасан зориулалтын дагуу байх;

4.3.2. хүүхдийн хөгжил, хамгааллын талаарх терийн бодлогод нийцсэн байх;

4.3.3. тухайн орон нутгийн хүүхдийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аюулгүй, таатай зорчих орчныг бүрдүүлсэн байх;

4.3.4. бүтээн байгуулалт дуусаж, ашиглалтад орсны дараа төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, орон тоо, үйл ажиллагааны болон ашиглалтын зардал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт үзүүлэх ачаалал зэрэг холбогдох судалгаа, тооцооллыг мэргэжлийн байгууллагаар гаргуулсан байх;

4.3.5. бүтээн байгуулалт дууссаны дараа төслийн тогтвортой байдлыг хангаж, шаардлагатай санхүүжилтийг хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтын хүсэлтийг хавсаргасан байх;



4.3.6.эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан газрын кадастрын зураг, газрын зөвшөөрөл авсан байх;

4.3.7.байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх.

4.4.Энэ журмын 4.2.1, 4.2.2-т заасан төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг дараах үе шат, цаглаврын дагуу зохион байгуулна:

4.4.1.“Хүүхдийн төлөө зөвлөл”-өөс жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Сангийн хөрөнгийн санхүүжилтээр шинээр барьж байгуулах, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

4.4.2.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсөл, арга хэмжээний саналыг энэ журмын 4.3-т заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, шаардлага хангасан төсөл, арга хэмжээний саналыг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ;

4.4.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь хүлээн авсан тесөл, арга хэмжээний саналыг Засгийн газраас баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.1-д заасны дагуу эрэмбэлэн дүгнэлт гаргаж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн хуралдаанд жил бүрийн 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор танилцуулж, санал авна;

4.4.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ журмын 4.4.3-т заасан саналыг харгалзан тухайн жилийн Төсвийн хуулийн төсөлд тусгуулах бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.

4.5.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн, эсхүл гишүүн олон нийтийн санал, хэрэгцээ шаардлагад үндэслэн хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих санал гаргаж, хуралдаанаар хэлэлцүүлж болно.

4.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.2.3-т заасан арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

4.7.Энэ журмын 4.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тухайн төсөл, арга хэмжээний талаар холбогдох этгээдээс нэмэлт мэдээлэл гаргуулах болон шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн багийг ажиллуулан дүгнэлт гаргуулж болно.

**Тав.Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын  
уралдаан тэмцээн, наадамд оролцож амжилт  
гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах**

5.1.Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцож, амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахад Засгийн газрын 2024 оны 139 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан жагсаалтыг баримталж, дараах журмаар олгоно:

5.1.1.хавсралтад заасан уралдаан тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн, байр эзэлсэн хүүхдэд доор дурдсан мөнгөн шагналын хэмжээнээс энэ журмын 5.1.2-т заасан хувиар тооцож олгоно:

№	Уралдаан тэмцээний ангилал	Спорт	Соёл, урлаг	Мөнгөн шагналын хэмжээ (сая.төгр)
1.	Тив, дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн, наадам	Алт	Гран-при	5.0
		Мөнгө	Тэргүүн байр	4.0
		Хүрэл	Дэд байр	3.0
2.	Олон улсын аварга шалгаруулах уралдаан тэмцээн, наадам	Алт	Гран-при	3.0
		Мөнгө	Тэргүүн байр	2.0
		Хүрэл	Дэд байр	1.0

5.1.2.уралдаан тэмцээн, наадмын төрөлд оролцогчдын тоо, зай, жин, өрсөлдөөний чанараас хамааран доор дурдсан хувиар мөнгөн шагнал олгоно: (оюуны спорт, роботик, хиймэл оюун ухаан, ур чадварын олимпиадад багийн төрлөөр оролцсон хүүхдийн тоог адилтган хамруулна.)



№	Тэмцээний ангилал	Жин, зай, төрөл тус бүрд оролцсон тамирчдын тоо		Олгох мөнгөн шагналын хувь
		Эрэгтэй	Эмэгтэй	
1.	Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн, наадам	20-оос дээш	15-аас дээш	100
		10-19 хүртэл	8-14 хүртэл	80
		9-өөс доош	7-оос доош	60

5.1.3.багийн төрөлд медаль хүртсэн багийн гишүүн тус бурийн уралдаан тэмцээн, наадмын оролцооны статистикийг харгалзан доор дурдсан хувиар тооцож, мөнгөн шагнал олгоно:

Оролцогч	Нийт оролцоонд хамаарах хувь	Олгох мөнгөн шагнал хувь
Багийн гишүүн	50 буюу түүнээс дээш хувь	100
	50 хүртэл хувь	50

5.1.4.тухайн уралдаан тэмцээн, наадам нь тамирчдын нийлбэр дүнгээр амжилтыг тооцож медаль олгодог бол зөвхөн нийлбэр дүнгийн медалийн төрөлд мөнгөн шагнал олгоно.

5.2.Энэ журмын 5.1-д заасан жагсаалт нь Засгийн газраас шагнаж урамшуулхаар заасан бусад журам, жагсаалттай давхаж байгаа тохиолдолд мөнгөн шагналыг аль нэг журамд зааснаар давхардуулахгүйгээр олгоно.

5.3.Тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь уралдаан тэмцээн, наадам дууссанаас хойш 30 хоногт багтаан энэ журамд заасан мөнгөн шагналын болзол хангасан хүүхдэд шагнал олгох хүсэлтийг дараах баримт бичгийн хамт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

5.3.1.шагнал урамшуулалт олгох тухай хүсэлт;

5.3.2.гадаад паспортын хуулбар;

5.3.3.амжилтыг гэрчилсэн дипломын хуулбар;

5.3.4.зохион байгуулагчийн албан ёсны цахим хаягт байршуулсан амжилт гаргасныг нотлох протокол, баримт бичгийн хуулбар;

5.3.5.мөнгөн шагналыг шилжүүлэх банкны нэр, дансны дугаар, хүлээн авагчийн нэр, регистрийн дугаар.

5.4.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.3-т заасан баримт бичгийг хянаж, шаардлага хангасан гэж үзвэл хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, 30 хоногийн дотор шийдвэрлүүлнэ.

5.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.1.1-д заасан нэг удаагийн мөнгөн шагналыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу дараа улирлын эхний сард багтаан олгоно.

**Зургаа.Сангийн хөрөнгөөр олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан, тэмцээн, наадамд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх**

6.1.Паралимп, Диффлимп, Тусгай Олимп болон олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг уралдаан, тэмцээн, наадамд оролцоход нь жилд 1 удаа дэмжлэг үзүүлнэ.

6.2.Засгийн газрын 2024 оны 139 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан жагсаалтад заасан уралдаан тэмцээн, наадамд оролцож, амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд энэ журмын 5.1.1-д заасан мөнгөн шагналыг олгоно.

6.3.Энэ журмын 6.1-д заасан дэмжлэг нь дараах төрөлтэй байна:

6.3.1.замын зардал;

6.3.2.тэмцээний хураамж;

6.3.3.олон улсад хүчинтэй эрүүл мэндийн даатгалын хураамж;

6.3.4.бэлтгэл сургуулилтад шаардагдах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмж;

6.3.5.бэлтгэл хийх заал, байрны түрээсийн зардал.

6.4.Энэ журмын 6.3-т заасан дэмжлэгийг дараах хувь, хэмжээгээр тооцож олгоно:

6.4.1.энэ журмын 6.3.1, 6.3.2, 6.3.3-т заасан зардал, хураамжийг 100 хувь;



6.4.2.энэ журмын 6.4.1-д зааснаас бусад төрлийн дэмжлэгийн 1 хүүхдэд ногдох нийт зардлын дээд хэмжээ 2.0 сая төгрөг, багийн төрөлд нэг гишүүнд ногдох зардлын дээд хэмжээ 1.0 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

6.5.Тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.1-д заасан дэмжлэг авах болзол хангасан хүүхдэд дэмжлэг олгох хүсэлтийг дараах баримт бичгийн хамт тэмцээн зохион байгуулагдахаас 30-аас багагүй хоногийн өмнө хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

6.5.1.дэмжлэг хүсэж буй тухайн хүүхэд, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлт;

6.5.2.уралдаан, тэмцээний зохион байгуулагчийн албан ёсны урилга, заавар, тухайн тэмцээний мэдээллийг байршуулсан албан ёсны цахим холбоос (линк);

6.5.3.уралдаан, тэмцээнд оролцуулах багийн бүрэлдэхүүнийг баталсан тухай спортын холбооны шийдвэр;

6.5.4.оролцогч хүүхдийн төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;

6.5.5.шаардагдах зардлын тооцоо (захиалгын хуудас, нэхэмжлэх).

6.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.5-д заасан баримт бичгийг хянаж, шаардлага хангасан хүсэлтийг 14 хоногийн дотор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

6.7.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 6.3-т заасан дэмжлэгийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гарснаас хойш 14 хоногт багтаан олгоно.

6.8.Тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой тохиолдолд энэ журмын 6.5.2-6.5.4-т заасан баримт бичгийг тухайн хүүхдээс шаардахгүй.

**Долоо. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан,  
тайланг олон нийтэд мэдээлэх**

7.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу гаргаж, хүргүүлнэ.

7.2. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийлгэж, дүгнэлт гаргуулна.

7.3. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага нь Сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлт, тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ.

7.5. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.2-т заасны дагуу санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

**Найм. Бусад**

8.1. Сангийн талаар доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1. сангийн хөрөнгийг бусдад барьцаалах, баталгаа гаргах;

8.1.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup>.3-т заасан арга хэмжээнээс бусад арга хэмжээнд дэмжлэг, урамшуулалт, тусламж, хандив олгох.

8.2. Сангийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцалж, үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй бөгөөд гэрээнд заасны дагуу зориулалтын бусаар зарцуулсан хөрөнгө, үүргийн гүйцэтгэлийг биелүүлээгүйгээс бий болсон хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



8.3. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 27.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.4. Энэ журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэж бүрдүүлсэн бол учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----

Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 139 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**ХҮҮХЭД ОРОЛЦОЖ АМЖИЛТ ГАРГАСАН ТОХИОЛДОЛД САНГААС ШАГНАЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ ОЛОН УЛС, ТИВ, ДЭЛХИЙН СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН, НААДМЫН ЖАГСААЛТ**

№	Ангилал		Оноосон нэр
1.	Спортын уралдаан, тэмцээний төрөл	Тивийн аваргын спортын төрөл	Олон улсын олимпийн хороо болон Азийн олимпийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн спортын төрлийн олон улсын холбооноос зохион байгуулгадаг Азийн аварга шалгаруулах тэмцээн (спортын бүх төрөл)
		Олимп, олон улсын тэмцээн	Олон улсын Паралимпийн хороо, Олон улсын Дифилимпийн хороо, Олон улсын Тусгай Олимпийн хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн спортын төрлийн олон улсын холбооноос зохион байгуулгадаг олимп, спортын уралдаан тэмцээн
		Оюун ухааны спортын тивийн аварга	Оюун ухааны спортын Азийн аварга шалгаруулах тэмцээн (жилд 1 удаа)
2.	Соёл, урлагийн уралдаан наадмын төрөл	Уран зураг	Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулгадаг “NEAR” олон улсын хүүхдийн уран зургийн уралдаан (жилд 1 удаа) Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зохион байгуулгадаг “Цайны зам” олон улсын уран бичлэгийн уралдаан
		Хөгжим, бүжиг	Бүгд Найрамдах Франц Улсад зохиогддог М.Магинь нэрэмжит олон улсын өсвөрийн төгөлдөр хуурчдын уралдаан Бүгд Найрамдах Чех Улсад зохиогддог Косианы нэрэмжит олон улсын залуу хийлчдийн уралдаан Бүгд Найрамдах Чех Улсад зохиогддог Хираны нэрэмжит өсвөрийн морин хийлчдийн олон улсын уралдаан Бүгд Найрамдах Чех Улсын Усти над Лабем хотноо зохиогддог “Уран чадварлаг төгөлдөр хуурчдын уралдаан (Виртуозы фотрепианной музыки)” өсвөрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан



		Оросын Холбооны Улсын Красноярск хотноо зохиогддог “Найдвар (Надежда)” олон улсын хөгжмийн уралдаан
		Монгол Улсад зохиогддог Ж.Чулууны нэрэмжит ёсвэрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
		Оросын Холбооны Улсад зохиогддог П.И.Чайковскийн нэрэмжит ёсвэрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
		Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохиогддог А.Дворжакийн нэрэмжит ёсвэрийн хөгжимчдийн олон улсын уралдаан
		Оросын Холбооны Улсад зохиогддог П.И.Чайковскийн нэрэмжит Консерваториас зохион байгуулдаг үлээвэр, цохивор хөгжимчдийн олон улсын уралдаан
		Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохиогддог Луй Шпор утсан хөгжимчдийн олон улсын уралдаан
		Оросын Холбооны Улсад зохиогддог С.Рахманиновын нэрэмжит төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан
		Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо зохиогддог ёсвэрийн төгөлдөр хуурчдын олон улсын уралдаан
		Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохиогддог Антон Рубинштейны нэрэмжит олон улсын хөгжмийн уралдаан
		Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо зохиогддог сонгодог бүжгийн олон улсын уралдаан
	Цирк	Монакогийн Вант Улсын Монте-Карлод зохиогддог дэлхийн ёсвэрийн циркчдийн их наадам
		Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ухань хотод зохиогддог олон улсын ёсвэрийн циркчдийн уралдаан
		Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохиогддог ёсвэрийн циркчдийн уралдаан

----000----

مذکور مذکور مذکور مذکور

«نەزەرەمەدەپىشىرىم سۈسىزدۇم. بىشىغۇرۇم نەزەرەمەدەپىشىرىم سۈسىزدۇم. بىشىغۇرۇم نەزەرەمەدەپىشىرىم سۈسىزدۇم..»

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ  
الْحُكْمُ لِلَّهِ رَبِّ الْعَالَمِينَ

دیستشیا م سیدم علی . عطیه علی . نسیله علی . علی . علی . سیدتاشیا

تامیم ۱۴۰۷ نصر ۱۴۰۷ ۹ ۶ هشتم  
جنگ ۱۴۰۷ ۹ پیغمبر ۱۴۰۷ هشتم  
هشتم ۱۴۰۷ هشتم

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

۶۰۰. «بی‌بی‌سی» عرب میتواند مسک (تندسنسی) «بسی» نیز — عرب عربی را در دادستنیشو. مسکم کو پیشتر میتواند کو بشر

**بَلْعَدِيرَ .. حَسْنَتْ عَمَّ بَلْعَدِيرَهُنَّزْ .. حَصَنَكَرَ قَبَدَشَهُنَّزْ**

جـ ٢٠١٠ مـ ٣٠٢٠١٠ جـ ٢٠١٠ مـ ٣٠٢٠١٠ جـ ٢٠١٠ مـ ٣٠٢٠١٠

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ  
وَاللَّهُمَّ مَسْكِنَ رَبِّ الْجَمَادِ  
أَنْتَ مَنْ يَعْلَمُ  
فَلَا إِلَهَ إِلَّا أَنْتَ  
أَنْتَ هُنْدُونَ  
أَنْتَ هُنْدُونَ

“我說，你這人真會說大話，我連一個字都沒有說過，你怎麼知道我會說大話呢？”

卷之三

ପ୍ରକାଶନ କମିଶନ : -

وَمِنْهُمْ مَنْ يَعْمَلُ مُحْرَماً وَمِنْهُمْ مَنْ يَعْمَلُ مُحْرَماً



ପ୍ରକାଶିତ...ହୀନ ଏବଂ ବିଜ୍ଞାନୀ ଏବଂ ମାନ୍ୟତାରେ ଉଦ୍‌ଦେଶ୍ୟ

卷之三

۵. ۳. ۶. بعدها پنجه و دسته را چنانچه که میتوانند در هر دو طرف از یک دسته قرار گیرند. دسته را با یک دسته دیگر میبندیم تا آنها میتوانند در هر دو طرف از یک دسته قرار گیرند. دسته را با یک دسته دیگر میبندیم تا آنها میتوانند در هر دو طرف از یک دسته قرار گیرند.



نر	مقدار میکرون مخصوص و معمولی	مقدار	مقدار مخصوص و معمولی	نر
۰	بین ۱۰۰ تا ۲۰۰	۱۰۰	بین ۱۰۰ تا ۲۰۰	۰
۰.۳	۱۰۰	۱۰۰	۱۰۰	۰.۳
۰.۴	۱۰۰	۱۰۰	۱۰۰	۰.۴
۰.۶	۱۰۰	۱۰۰	۱۰۰	۰.۶

٥٠	٥٠	٥٠	٥٠	٥٠
٥٠	٥٠	٥٠	٥٠	٥٠

هشتمین بیان مکانیزم پسندیدگر خود را در محدوده ۰-۵۰٪ تضليل می‌داند.

۳۰۳۰. میسنن بعده سنتنیم بعنه نسخه هزار و ده سال است:

۲۰۰۰ د.ت شش شو عاصمه هم دسته هایی دارند :

۲۰۰۰ م. سعیدیم بن دکتر سلامه شیخیه عمر دستگذار :

تَشْسِيرٌ وَتَسْوِيرٌ وَتَسْلِيمٌ. يَدْعُونَ عَمَّا يَرَى  
كُلُّ مُسْتَقْبَلٍ عَمَّا يَرَى كُلُّ مُسْتَقْبَلٍ عَمَّا يَرَى

دنتسپریم یعنی دندانهای پخته شده در میانه های دندانهای مسنت است که میتواند در میانه های دندانهای مسنت قرار گیرد و این دندانهای مسنت را بسیار ساده و آسان می کند. این دندانهای مسنت میتوانند در میانه های دندانهای مسنت قرار گیرند و این دندانهای مسنت را بسیار ساده و آسان می کنند.

جَمِيعَ الْكُلُوبِ

ଶ୍ରୀମଦ୍ଭଗବତ୍ । ୨ ପାଠୀଙ୍କଣ୍ଡ :

କୁଣ୍ଡଳ ପାତାରେ ଦେଖିଲୁ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା

وَمِنْهُ الْمَلَكُ هُوَ صَاحِبُ الْمُلْكِ وَالْمُلْكُ لِلْمُلْكِ لِلْمُلْكِ

۶-۵-۰- میتوانیم یعنی میتوانیم چون حسن نیز هم را بخواهیم بخواهیم تا در اینجا میتوانیم باشیم و میتوانیم باشیم (باید) :  
۶-۵-۰- بدینهاست که میتوانیم باشیم و میتوانیم باشیم (باید) :  
۶-۵-۰- میتوانیم باشیم و میتوانیم باشیم (باید) :

۶.۲.۳. بعده سه نیم ساعت عالم پنجه ایشان را درست می کنند.

۶۰۳: میتوانیم باید این سه نسبت را همچنان که در میان دو دسته مذکور شده باشند، میتوانیم باید این سه نسبت را همچنان که در میان دو دسته مذکور شده باشند،

**دَسْتِرِيْسِرْ وَسِنِيْدْ** ٦٠٦. نَهْدَمْ. دَنْ بَعْدَهُنْ تَمْ عَدْدَهُنْ عَمْ سَنْتَهُنْ دَسْتِرِيْسِرْ مَهْدَهُنْ تَمْ دَرْبَشَرْ وَ دَسْتِرِيْسِرْ دَنْ بَعْدَهُنْ تَمْ عَدْدَهُنْ عَمْ سَنْتَهُنْ

٦. ٢. - نعم، لآن عیل کم پرداختا می ساختند و بسته سایر هدایت های این داده ها را در اینجا خواهی داشت.

مُعَذِّبٍ .. مُدْسِئٍ (مُعَذِّبٍ) مُسْتَهْلِكٍ .. مُسْتَهْلِكٍ (مُعَذِّبٍ) مُسْتَهْلِكٍ ..

بَلْ كُلُّهُ . كَعْدَنِ شَمْسٍ نَّاسِدَنِ شَمْسَهُ ..

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ  
الْحَمْدُ لِلَّهِ رَبِّ الْعَالَمِينَ  
الْكَفَرُ بِهِ مُنْكَرٌ وَالْإِيمَانُ بِهِ حَقٌّ  
لِلَّهِ الْعَلِيِّ الْعَزِيزِ لَا يَنْهَا  
أَيْدِيهِنَّ وَلَا يَمْكُرُونَ  
لِلَّهِ الْعَلِيِّ الْعَزِيزِ لَا يَنْهَا  
أَيْدِيهِنَّ وَلَا يَمْكُرُونَ

**ميسن** **عمر** **تسنن** **عمر** **هـ** **٢٠** **١٥** **١٤** **١٣** **١٢** **١١** **١٠** **٩** **٨** **٧** **٦** **٥** **٤** **٣** **٢** **١** **٠**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 13.1.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтанзэрэл, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг дарга наарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 144 дүгээр тогтоол, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 441 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

С.БЯМБАЦОГТ

۳۵۰ پنجم و ۱۰ فشتان میتوانند تراویح - و سعید

۰۲۶

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

تاجیم محدث دیار ۹۵۰۰۰۰۰۰۰۰۰۰۰۰

۶- «بَلَدِي» نَسْطَبَتْ عَمَّا تَرَكَنَا سَلَامُهُ فَوْجَيْنَاهُ سَلَامٌ وَسَلَامٌ وَسَلَامٌ

مکتبہ علامہ

بِهِ - بَعْدَهُ - بَعْدَنْ

مکتبہ دلیل شریف

ଶ୍ରୀମଦ୍ଭଗବତ



Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 140 дүгээр тогтоолын хавсралт

## ИРГЭНИЙГ ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД ЭРҮҮЛ МЭНДЭЭР ТЭНЦҮҮЛЭХ БОЛОН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь иргэнийг цэргийн жинхэнэ алба хаах, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудыг эрүүл, чийрэг бие бялдартай бие бүрэлдэхүүнээр нөхөн хангахад оршино.

1.2. Иргэнийг цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх, тайван цагт алба хаах офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн болон цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах, оюутан-цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах, энхиig дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргахад энэ журмыг баримтална.

### Хоёр. Хугацаат цэргийн албанад татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэний эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах

2.1. Иргэнийг тайван цагт цэргийн жинхэнэ албанад тэнцүүлэхэд эрүүл мэндийн байдлыг үндсэн шалгур үзүүлэлт болгоно.

2.2. Хугацаат цэргийн албанад татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

2.2.1. хугацаат цэргийн албанад татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэн эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулж, нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулсан байх бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ (элэг, бөөрний үйл ажиллагаа, глюкоз), БЗДХ-ын илрүүлэх шинжилгээ (TRNA, RPR), элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, цээжний рентген шинжилгээ (техник, хэрэгсэл ашиглах боломжгүй тохиолдолд уушгины флюор), зүрхний цахилгаан бичлэг, хэвллийн чанд авиан шинжилгээ, оношилгоог хийлгэж, холбогдох баримтыг, хэрэв архаг хууч өвчтэй бол түүнийг нотлох бичиг баримтыг цэрэг татлагын байранд авч ирнэ;

2.2.2.аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Цэрэг татлагын товчооны эмч нарын комисст аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын дотор, зүрх судас, халдварт-сүрьеэ, гэмтэл-мэс засал, нүд, шүд, чих-хамар хоолой, мэдрэл, сэтгэц, арьс-харшил, дурс оношилгооны зэрэг нарийн мэргэшлийн эмч, сэтгэл зүйч ажиллана;

2.2.3.комиссын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа эмч хугацаат цэргийн албан д татагдсан болон гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаах хүсэлт гаргасан иргэнд үзлэг хийж, энэ журмын 1, 2, 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн иргэн цэргийн жинхэнэ албан д биеийн эрүүл мэндээр тэнцэх эсэх талаар дүгнэлт гаргана;

2.2.4.үзлэг хийсэн эмч энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан “Эрүүл мэндийн үзлэгийн хуудас”-т “Цэргийн жинхэнэ албан д эрүүл мэндээр тэнцэнэ”, эсхүл “Цэргийн жинхэнэ албан д эрүүл мэндээр тэнцэхгүй” гэсэн тэмдэглэгээ хийх бөгөөд цэргийн жинхэнэ албан д биеийн эрүүл мэндээр тэнцээгүй иргэний өвчиний оношийг олон улсын код болон монгол хэл дээр тэмдэглэнэ. Эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг Цэрэг татлагын товчооны ерөнхий эмч баталгаажуулна;

2.2.5.цэргийн нэгтгэл, анги, байгууллагын цэрэг хүлээн авах комисс нь аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Цэрэг татлагын товчоотой хамтран ажиллаж, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, цэргийн нэгтгэл, анги, байгууллага байрлах бусийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн өвчиний оношийг нь тодруулах шаардлагатай иргэнийг харьяа Цэргийн штабт буцаана.

2.3.Цэргийн эмнэлгийн комисс нь аймагт 2 жилд нэг удаа, нийслэл (дүүрэг)-д жилд хоёр удаа аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн энэ журмын 5 дугаар хавсралтад заасан өвчин, эмгэгийн улмаас эрүүл мэндийн байдлаар цэргийн албан д тэнцэхгүй иргэнийг тайван цагт хугацаат цэргийн албан д татахаас чөлөөлөх шийдвэрийг тухайн жилийн цэрэг татлага явагдаж дууссанаас хойш 30 өдөрт багтаан гаргана. Уг шийдвэрийг аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг дарга баталгаажуулна.

2.4.Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр эрүүл мэндийн байдлаар цэргийн албан д тэнцэхгүй болох нь тогтоогдож, тайван цагт хугацаат цэргийн албан д татахаас чөлөөлөгдсэн иргэний цэргийн үүрэгтний үнэмлэх дээр цэргийн эмнэлгийн комиссын дарга, аймаг, дүүргийн Цэргийн штабын дарга нар тус тус гарын үсэг зурж баталгаажуулна.



2.5.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага иргэнийг эрүүл мэндийн байдлаар тайван цагт хугацаат цэргийн албандаа татахаас чөлөөлөх ажиллагаа болон шийдвэрт хяналт тавина.

2.6.Аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (цаашид “Цэргийн штаб” гэх) нь хугацаат цэргийн алба хаах насын иргэдийн эрүүл мэнд болон сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх сургалтыг тухайн нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн болон цэргийн нэгтгэл, анги, байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж, дүнг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

2.7.Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн цэргийн штабтай хамтран хугацаат цэргийн алба хаах насын иргэн болон цэргийн албаны ээлжит татлагаас чөлөөлөгдсөн иргэний, хугацаанаасаа өмнө эрүүл мэндийн шалгаанаар чөлөөлөгдсөн хугацаат цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэн тэднийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.8.Хугацаат цэргийн албанаас эрүүл мэндийн байдлаар түр чөлөөлөгдсөн иргэн эрүүл мэндийн даатгалaa баталгаажуулж, харьяа эрүүл мэндийн байгууллагын эрүүлжүүлэх төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдана.

2.9.Цэргийн алба хаагчийг цэргийн тангараг өргөхөөс өмнө энэ журмын 2.2.5-д заасны дагуу эрүүл мэндийн байдлаар буцаасан тохиолдолд холбогдох зардлыг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хариуцна.

#### **Гурав.Офицер, ахлагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах**

3.1.Цэргийн жинхэнэ алба хааж байгаа офицер, ахлагч (цаашид “офицер, ахлагч” гэх)-ийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

3.1.1.офицер, ахлагчийг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, цэргийн эмнэлгийн комисс энэ журмын 1, 2, 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргана;

3.1.2.цэргийн эмч нарын комисс нь энэ журмын 5 дугаар хавсралтад заасан өвчин, эмгэгтэй офицер, ахлагчийг тайван цагт цэргийн жинхэнэ албандаа эрүүл мэндээр тэнцэхгүй талаарх дүгнэлтийг гаргана.

3.2. Цэргийн жинхэнэ албанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй гэсэн үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдсөн офицер, ахлагчийг цэргийн албанд эгүүлэн авах, иргэнийг офицер, ахлагчийн албан тушаалд томилоход энэ журмын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамруулж, дүгнэлт гаргана.

**Дөрөв. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах**

4.1. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

4.1.1. Цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй болсон цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн албанаас чөлөөлөх шийдвэрийг цэргийн эмч нарын комисс гаргана;

4.1.2. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албанаас эрүүл мэндээр тэнцэхгүй гэсэн үндэслэлээр чөлөөлөгдсөн цэргийн алба хаагч оршин суух газрын харьяа эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийг нөхөн сэргээлгэх үйлчилгээ авч, хөдөлмөрийн чадвар алдалтыг эрх бүхий байгууллагаар тогтоолгон холбогдох хууль тогтоомжийн дагуу нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдана;

4.1.3. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч нь алба хаах хугацаанд гэнэтийн ослын улмаас цэргийн жинхэнэ албанаас эрүүл мэндээр чөлөөлөгдсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдана.

**Тав. Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах**

5.1. Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

5.1.1. Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах иргэн, цэргийн алба хаагч Цэргийн төв эмнэлэг, эсхүл Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана;



5.1.2.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагч Цэргийн төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдана;

5.1.3.цэргийн эмнэлгийн комисс нь энэ журмын 1, 2, 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн дүгнэлт гаргаж, дүгнэлтээ цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн шалгалтын болон энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулах комисст хүргүүлнэ.

### **Зургаа.Бусад зүйл**

6.1.Иргэн цэргийн албанд татагдах болон орохдоо архаг суурь өвчинөө нуун дарагдуулсны улмаас цэргийн жинхэнэ алба хаах хугацаанд уг өвчин сэдэрч, цэргийн албанаас биеийн эрүүл мэндээр чөлөөлөгдсөн тохиолдолд цэргийн нэгтгэл, анги, байгууллагаас гарсан эрүүл мэндийн үйлчилгээний болон холбогдох бусад зардлыг тухайн иргэн хариуцна.

6.2.Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---



“Иргэнийг цэргийн жинхэнэ албандаа эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”ын 1 дугаар хавсралт

## ИРГЭНИЙГ ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД ЭРҮҮЛ МЭНДЭЭР ТЕНЦҮҮЛЭХ БОЛОН ЦЭРГИЙН АЛВА ХААГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХДОХ ХАРГАЛЗАХ ӨВЧИН, ЭМГЭГИЙН ЖАГСАЛТ

Д/д	Өвчиний нэр	Өвчиний олон улсын ангинын код	Офицер, ахлагч	Цэрийн гэрээт, хугацаат цэргийн алба хаагч	Элсэгч, сурагч, сонсогч, оюутан цэрэг, Магистрант, докторант	Энхийт дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчид
1	2	3	4	5	6	7
ЦУСНЫ ЭРГЭЛТИЙН ТОГТОГЦООНЫ ӨВЧИН						
1	Хэрэгэлийн гаралтай зурхийн архаг өвчин, Хэрэгэлийн гаралтай хавалга болон гол судасны хаварсан болон дан гэмтэл	105-109	Цурсны ЭРГЭЛТИЙН ТОГТОГЦООНЫ ӨВЧИН “Тэнцэнэ” (Зурхийн хөндийн тэлэгэлдлийн хөнгөн зэрэг, хавхалтын наэгээлтийн талбай 1-р зэрэгрээр нарийсан, зурхийн зуун ховдлын агшилтын үйл ажиллагаа алдагдаагүй бол)	“Тэнцэнэ”	“Тэнцхүй”	“Тэнцхүй”
2	Цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн тажигт	Q20-Q28	(ховдол болон тостгүүр хоорондын таславчийн цоорхой, уушлины артерийн цоорхой мэс застлаар засагдах боломжтой бол)	“Тэнцэнэ”	“Тэнцхүй”	“Тэнцхүй”
3	Зурхний бах	120.0-120.9	(эмчийн хянагтад байх)	“Тэнцэнэ”	“Тэнцхүй”	“Тэнцхүй”



4	Зүрхний шилдээс	I21-I22	“Тэнцэн” (Өвчлийн дараа 6 сарын хугацаанд нэхэн саргээж эмчилгээ хийдэж дахин өвчлөөгүй бол)	“Тэнцэхгүй”
5	Хордлогоо, харшлын гаралттай миокардит	I40-I41	“Тэнцэн” (Хэм алдагдлын хүндтэй хэлбэрүүд, Миокардын тэжээлгүйтэл болон хавхалтын вегетаци Ууссанзээс бусад)	“Тэнцэхгүй”
6	Тосгур хориг II зэрэг	I44.1	“Тэнцэн” (24 цагийн зуурхний цахилгаан бичигт хоногийн нийт зуурхийн цохилт буураатгай ба бусад хэм алдагдал ипрээгүй бол) “Тэнцэхгүй” (24 цагийн зуурхийн цахилгаан бичилгээт 2.5 секундээс дээш хугацааны завсралгата-пауз илэрсэн бол)	“Тэнцэхгүй”
7	Ховдоп хугацаанаас урьдаж туйлгүйшиг	I49.3	“Тэнцэн” (24 цагийн зуурхний цахилгаан бичигт хоногийн нийт зуурхийн хэм алдагдал 15 хувь ба түүнээс бага илэрсэн бол)	“Тэнцэхгүй” (Хэм алдагдлын хэлбэрээс хамаарна)
8	Тосгур хугацаанаас урьдаж туйлгүйшиг	I49.1	“Тэнцэн” (Хавсарсан хэм алдагддап илрээгүй Аблаци эмчилгээ хийх боломжтой бол)	“Тэнцэхгүй”
9	Вольф-Паркинсон Уайтын хам шинж	I45.6	“Тэнцэн” (Хавсарсан хэм алдагддап илрээгүй Аблаци эмчилгээ хийх боломжтой бол)	“Тэнцэхгүй”

10	Атеросклероз	170-170.9	(өвчний явцас шалтгаална)	“Тэнцэхгүй”
11	Кардиомиопати	142.0-143.8	“Тэнцэнэ”	“Тэнцэхгүй”
12	Перикардитын бүх төрлийн хэлбэрүүд	130-132	(үнхэлцгэх хальс хатуурсан, наапдаа үүссэн, зурхий шахах үйл ажиллагаанд нийвэлэл үзүүлсэн гэх мэт хүндэрэлгүй бол)	“Тэнцэхгүй”
13	Гол судасны цуулхэн	171-171.9		“Тэнцэхгүй”
14	Цусны даралт ихсэх өвчин	110-113	(өвчний 1, 2 дугаар үеийн эмчилгээ үр дүнтэй бол)	(артерийн даралтын 2 ба түнээс дээш зэрэг)
15	Шинж артерийн даралт ихсэлт	115		“Тэнцэнэ” (бай эрхтний гэмтэл, эмчилгээнэй үр дүнгээс хамаарна)
16	Тахикарди, тодорхойгүй (синусын тахикарди)	R00.0		“Тэнцэнэ”
17	Брадикарди, тодорхойгүй (синусын брадикарди)	R00.1		“Тэнцэнэ” (үзлэгийн үед зурхий цохильтын тоо 50 ба түнээс дээш бол)
18	Гисийн баруун хөхлийн бутэн хориг			“Тэнцэнэ” “Тэнцэхгүй”



АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН					
19	Уушгинь үрэвсэл	архаг	J10-J18.9	(өвөрмөц бус уусгэгчүй, амьсталын дутагдлын шинжгүй боловч олон дахин сэдэрлэлтэй, уушгинь баатамж 10 хвиас дээш буурсан, эмчилгээний үр дүн муу бол тэнцэхгүй)	“Тэнцэхгүй”
20	Гүурсан архаг үрэвсэл	холойн холройн	J41-J42	(ижээхэн сэдэрэлгтэй, цагаан мөгөврөсөн хоолойн дистрекци өөрчлөлтэй, эмчилгээний үр дүн муу бол тэнцэхгүй)	“Тэнцэхгүй”
21	Уушгинь хальсны боловч түүний үлдэц	ялтан урзвсэл	J90-J92.9 J93-J94.9	(амьсталын дутагдлын шинжгүй боловч спирораммын үзүүлэлтгүүдийн өөрчлөлтийг харгалзан үзэх)	“Тэнцэхгүй”
22	Гүурсан баттраа	холойн	J45-J46		“Тэнцэхгүй”
23	Уушги тоожиж		J60-J65	(өвчиний хүрч архаг, давшилтгэй хэлбэрээс бусад үед)	“Тэнцэхгүй”
24	Уушгинь терүүхийн гажиг	бусад	Q33.8		Тэнцэхгүй
25	Уушгинь халдвэрлэгдсан опон үйлчилхийт эмэгт		Q33.0	(эмчилгээний үр дүнгээс хамаарна)	“Тэнцэхгүй”
26	Уушги хатуурах боловч тэлэгдэх		J43.0- J43.9		“Тэнцэхгүй”
27	Уушгинь шохойжилт			(хэмжээнээс хамаарна)	“Тэнцэхгүй” (уушгинь шохойжилт 0.5 см-ээс их бол)
28	Гүурсан тэлэгдэх өвчин	холойн	J47		“Тэнцэхгүй”

29	Завсрын зонхилон амьсгалын бусад агаектаз	Эдийг гэмтээх замын өвчин,	J84	“Тэнцэхгүй”
30	Уушлины хавдар	Цээжний хальсны Урэслийн үлдэц, хагасгааны Улдцийн улмаас өрц, ушиглины наалдаж	Ялтан ялтан халс, уссэн ялсан халс, ушиглины наалдаж	C33
31	Уушлины берелт	Цээжний хальсны Урэслийн үлдэц, хагасгааны Улдцийн улмаас өрц, ушиглины наалдаж	Ялтан ялтан халс, уссэн ялсан халс, ушиглины наалдаж	J44
32	Уушлины берелт	Цээжний хальсны Урэслийн үлдэц, хагасгааны Улдцийн улмаас өрц, ушиглины наалдаж	Ялтан ялтан халс, уссэн ялсан халс, ушиглины наалдаж	J44
ХООЛ ШИНГЭЭХ ЭРХТНИЙ ЭМГЭГ				
33	Ходоод, гэдэсний шархлаа	Ходоод, 12 хуруу	K25-K28	“Тэнцэнэ”
34	Олон дахилттай ходоодны шалбархайт үрэвэслэл	Олон дахилттай ходоодны шалбархайт үрэвэслэл	K29	“Тэнцэнэ”
35	Кроны өвчин	(эмчилгээний үр дүнд эзэнэтшийн байдалд орсон бол)	K50	“Тэнцэхгүй” “Тэнцэхгүй” “Тэнцэхгүй” “Тэнцэхгүй”



36	Будүүн гэцэсний архаг Урэвсэл	K51	“Тэнцэнэй”	“Тэнцэхгүй”	“Тэнцэхгүй”	“Тэнцэхгүй”
37	Будүүн өвөрмөц шархлаа	K51.0-K51.9 бус	“Тэнцэнэй” (эмчилгээний ур дунд эзэнтшилийн байдал орсон бол)	“Тэнцэнэй”	“Тэнцэхгүй”	“Тэнцэхгүй”
38	Тогтолчигийн эзэлний Урэвсэл	явлтай архаг	K72.0-K72.9	“Тэнцэнэй” (лабораторийн болон бусад шинжилгээний дүн, эмнэл зүйгээр эзлэгний улil ажиллагааны хамрал даамжирч, гүнзгийрсэн тохиолдлос бусад)	(элэгний эсийн АЛАТ, АСАТ 60-аас дээшгүй, вирусгүй тохиолдолд)	“Тэнцэнэй”
39	Элэгний хатуурал		K74.0-K74.6	“Тэнцэнэй” (эмчилгээний ур дунд эзэнтшилийн байдал орсон бол)	“Тэнцэнэй”	“Тэнцэхгүй”
40	Элэгний идэвхтэй архаг Урэвсэл		K73.0-K73.9	“Тэнцэнэй” (эмчилгээний ур дунгээс хамаарна)	“Тэнцэнэй”	“Тэнцэнэй”
41	“A” гаралтай хүрч Урэвсэл	вирусийн эзгний	B15.0-B15.1	“Тэнцэнэй”	“Тэнцэнэй” (эддэрснээс хойш 6 сараас дээш хугацаанд сэдрэл өгөвгүй, шинжилгээээр элэтний үйл ажиллагааны взуулгат өөрчлөлтгүй бол)	“Тэнцэхгүй”



42	"B", "C" вирусийн шалггаантай элгний хүрц үрэвсэл	B16.0- B16.9, B17.1	(Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)
43	"B", "C", "D" вирусийн шалггаантай элгний архаг үрэвсэл	B18.0- B18.2	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дүн өвчин яваас хамаарна)
44	Элгний бусад өвчин	K76.0	"Тэнцэнэ" (Элгний дутагдлын шинж илрээгүй бол)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дун энэтшлийн байдал бол)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дун энэтшлийн байдал бол)
45	Нойр архаг үрэвсэл	К86	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дун мүү, олон дахин сэдрэлтэй бол)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дун энэтшлийн байдал бол)	"Тэнцэнэ" (Эмчилгээний үр дун энэтшлийн байдал бол)



46	Элэгний хоргуй хавдар	судасны D18.0	“Тэнцэнэ” (хэмжээ нь 5 см-ээс ихгүй бол)	(хэмжээ нь 5 см-ээс их эсвэл 2-оос дээш тоотой бол тэнцэхгүй)
47	Бөөний тэвшинцрийн архаг Урэвэсл	N11	“Тэнцэнэ” (бөөний дутагдлын шинж илрээгүй, бөөний уйл ажиллагаа болон шээсний өрөхийн шинжилгээ хэвийн байх)	“Тэнцэнэ” (бөөний дутагдлын шинж илрээгүй, бөөний уйл ажиллагаа болон шээсний өрөхийн шинжилгээ хэвийн байх)
48	Бөөний түүдэнцрийн архаг Урэвэсл	N03		“Тэнцэхгүй”
49	Цочмог нефритийн хам шинж	N00	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дун, өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”
50	Түргэн нефрит хам шинж	даамжрах N01		“Тэнцэхгүй”
51	Шэссээр дахиллтад ба тогтвортойтор цус гарах, хам шинж	N02 (R31)	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дун, өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”
52	Чихрийн шилжигний түүдэнцрийн эмзэг	N08.3	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дун, өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”

53	Бөөр тэвшинцэр холбоос бөглөвөх	устах ба шээлэйн	N13.0	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дүн, өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”
54	Эм, хүнд метаплаас улбаалсан бөөрний сувганцрын завсрын эдийн ба сувганцрын эмзэг		N14.2	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дүн, өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”
55	Бөөрний дүгнэгшил	цочмог	N17	“Тэнцэхгүй” (эмчилгээний дараа 1 жилийн дотор сэдрэл өгсөн тохиолдолд)	“Тэнцэхгүй”
56	Бөөрний дүгнэгшил	архаг	N18	“Тэнцэхгүй” (туудэнцрийн шуулт 89 мл/мин доос бол)	“Тэнцэхгүй”
57	Төрөлхийн, опдимол, тодорхойгүй шалгтаант нэг ба хоёр талын жижиг бөөр		1 талын N27.0 2 талынх N27.1	“Тэнцэнэ” (бөөрний үйл ажиллагааны алдагдалгүй бол)	“Тэнцэхгүй”
58	Хоёр талын бөөрний опон тооны уйланхай		N28.1		“Тэнцэхгүй”
59	Төрөлхийн опдимол нэг бөөрний уйланхай (3 см-аас их, 2 болон түүчээс дээш тоотой бол)		N28.1, Q61	“Тэнцэнэ” (бөөрний үйл ажиллагаа алдадаагүй бол)	“Тэнцэхгүй”
60	Шалтгаан тодорхойгүй давсагны мэдрэл булчингийн үйл ажиллагааны хямрап		N31.9	“Тэнцэнэ”	“Тэнцэхгүй”



61	Мэс заслын дараах бөөрний дутагдал	N99.0	“Тэнцэхгүй” (түүдгэнчрийн шуулт 89 мП/мин доош бол)	“Тэнцэхгүй”
62	Бөөр үнжилтийн дугаар зэрэг	N28.8	“Тэнцэнэ”	“Тэнцэхгүй”
Цус, цус боловсруулах эрхтний ёвчин				
63	Верльгофын ёвчин	D69.3	“Тэнцэнэ” (зэнэгшилийн байдалд 1-зэс дээш жил болсон бол)	“Тэнцэхгүй”
64	Шалтгаан тодорхойгүй ялтас эс цөөрөх	D69.4- D69.6	“Тэнцэнэ” (эмчийн хяналтад байх бөгөөд ёвчний язвч, зэнэгшилийн байдлаас хамаарна)	“Тэнцэхгүй”
65	Дэлгүү томролт	R16.1	“Тэнцэнэ” (үйл ажиллагааны алдагдалгүй бол)	“Тэнцэхгүй”
66	Шенглейн Генохын ёвчин	D69.0	“Тэнцэнэ” (зэнэгшилийн байдалд 1-зэс дээш жил болсон бол)	“Тэнцэхгүй”
67	Аутомимунны цус баагадалт	D59.4		“Тэнцэхгүй”
68	Цус төлжилгүйдлийн цус баагадалт	D61		“Тэнцэхгүй”
69	Полицитеми (эржтерми)	D75		“Тэнцэхгүй”
70	Цусны цагаан цопцос ховордох	D72		“Тэнцэхгүй”
71	Витамин В12 болон төмөр дутагдлын цус баагадалт	D50-D51.9	“Тэнцэнэ” “Тэнцэнэ” (хавсрсан ёвчнөөс шалтгаалж бол)	“Тэнцэхгүй”



72	Лимфогрануломатоз	D71		“Тэнцэхгүй”
73	Гемофилия (A,B)	D66.0-D67		“Тэнцэхгүй”
74	Хадуур эст цус багцаалт	D57.8		“Тэнцэхгүй”
75	Төрөлхийн сфероцитоз			“Тэнцэхгүй”
76	Талассемия	D56		“Тэнцэхгүй”
<b>ДОТООД ШҮҮРЭЛ, БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ӨВЧИН</b>				
77	Бамбай булчирхайн өвчинүүд	E05	“Тэнцэнэ” (эмчилгээний үр дүн өвчиний явцаас хамаарна)	“Тэнцэхгүй”
78	Чихрийн шижин	E10-E14	“Тэнцэнэ” (бай эрхтний гэмтлээс хамаарна)	“Тэнцэхгүй”
79	Хүрэл өвчин	Q82.5		“Тэнцэхгүй”
80	Гиперхроматоз	E61	“Тэнцэнэ”	“Тэнцэхгүй”
81	Тулай өвчин	M10	(эмчилгээний үр дүнгээс хамаарна)	“Тэнцэхгүй”
<b>“Тэнцэхгүй”</b>				
82	Таргалалт (Бодисын солилцооны хам шинж)	E66	“Тэнцэхгүй” (хоол тэжээл, хедэлгэеныйн дэглэмээс үүдэлгээний 2, 3 дугаар зэртийн таргалалтын харилцан эмчлэхэд 9 сарын дотор үр дун өгөхгүй бол)	“Тэнцэхгүй” (хоол тэжээл, хедэлгэеныйн дэглэмээс үүдэлгээний 2, 3 дугаар зэртийн таргалалтыг харилцан эмчлэхэд 9 сарын дотор үр дун өгөхгүй бол)



ЯС, БУЛЧИНГИЙН ТОГТОЛЦОО, ХОЛБОХ НЭХДЭСИЙН ОВЧИН			
83	Артрозууд	M15-M19	“Тэнцэхгүй” Үүний мөгөөрслөг эдийн хатуурлын улмаас хөдөлгөөн хягаарлагдсан, хэвийн байдал алдагсан, байнын эмзэглэлтэй бол)
84	Олон үүний хэрлэг тест үрэвсэлт эмтэгшил	M05-M06	“Тэнцэхгүй”
85	Үений үрэвсэл зангилаат	M30	“Тэнцэхгүй”
86	Улаан чоон яр	M32	“Тэнцэхгүй”
87	Даамжрах тогтолцоот хатуурал (Склеродерм)	M34	“Тэнцэхгүй”
ХОРДЛОГО			
88	Туяаны хордлого	T66	“Тэнцэхгүй”
89	Фосфор органик болон бусад хорт бодисын хордлогын дараах байдал	T53-T57	“Тэнцэнэ” (уржаг улдэцгүй бол)
90	Хунд металлын архаг хордлого, тууний улдэц	T53-T57	“Тэнцэхгүй”
91	Хүчин хордлого, тууний улдэц (хоол боловсруулах замын тулэгдлийн улдэц, нарийсалт)		“Тэнцэхгүй”



НҮД, ТҮҮНИЙ ДАЙВРЫН ӨВЧИН						
Зовхи, нулимын эрхтэн, ухархайн эмгэг						
92	Хүрц болон архаг блефарит	H01.0	“Тэнцэнэ”	“Тэнцэхгүй”	“Тэнцэнэ”	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)
93	Зовхи гадатш эргэх, дотогши урвах	H02.0-1	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)			
94	Туулайн нүд	H02.2	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)		“Тэнцэнэ”	
95	Зовхи буух (Блефароптоз зэрэг)	H02.4 II-III	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)		“Тэнцэхгүй”	“Тэнцэнэ”
96	Халдварт өвчний үеийн зовхинны эмгэг	H03	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)		“Тэнцэхгүй”	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)
97	Нулимын эмгэгүүд	H04.0- 04.9	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)		“Тэнцэхгүй”	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөгүй бол)
98	Нулимын замын таж хөгжил	C10.6			“Тэнцэхгүй”	



Налихын эмгэг				
99	Нудний бүрхэвчийн үрэвсэл	салст H10.4	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол)	“Тэнцэхгүй”
100	Нудний цагаан бурхулийн сорижкилт	H16	“Тэнцэхгүй” (дахисан птерилитум нь эвэрлэг рүү 3 мм-ээс илүү ургасан бол эсвэл ёминь нь 2 удаа мэс засалд ороод хараанд нөлөөтжк 0,5-аас доош шилээр засагдахгүй бол)	“Тэнцэхгүй”
101	Эвэрлэгийн хурц болон архаг үрэвсэл (бүх төрлийн шалгтаантай кератит)	H16	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол)	“Тэнцэхгүй”
102	Эвэрлэгийн цагаа (мананцаар, толбо, цагаа, нь харах төвийн нөлөөлнөөс шилтээр засгадахгүй бол)	H16.4, H17.8	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд чадвар, хараанд нөлөөлөөгүй бол)	“Тэнцэхгүй”
103	Эвэрлэгийн дистрофийн хэлбэрүүд	H18.5	“Тэнцэнэ” (эмчлэгдээд засагдсан, хараанд нөлөөлөөгүй бол)	“Тэнцэхгүй”

104	Эвэрлэг солих мэс засал хийгүүгээн бол	H18		“Тэнцэхгүй”
105	Судаслаг болон солонгон бурхулийн хүрц болон архаг урэвсэл	H20, H21	(эмчлэгдээд засагсан, хараанд нөлөөлөөгүй бол)	“Тэнцэхгүй”
106	Солонгон бурхулийн аномали хөгжил (поликиори, том хэмжээний мемброн, колобома)	H22	(харах чадвар төвийн харванд нөлөөлж, 2 нүдний хараа 0,5-аас доошилсон, шилээр засагдахгүй бол)	“Тэнцэхгүй”
107	Солонтон бурхулийн үрэвслийн дараах сорвижилт, наадлыуд	H22.8	(хараанд нөлөөлж шилээр засагдахгүй бол)	“Тэнцэхгүй”
108	Гэмтлийн мидриаз, харааны мемброн нөлөөлж засагдахгүй бол	H21.4	Гаралтай хүүхэн сарьс хараанд шилээр засагдахгүй	“Тэнцэхгүй”
			Болорын эмгэг	
109	Болор цайх өвчин афаки, эсвэл нь хиймэл тавмылсан бол	H26-27	(хиймэл болортой, харааны чадварт нөлөөлөөгүй шилээр засагдаж байгаа бол)	“Тэнцэхгүй”



110	Болрын болор мэс заслаар хиймэл болгоргүй бол	Мултрапл, Н26-27		“Тэнцэхгүй”
111	Төрөлхийн хөөрдогчоор катарткт	боловн үүссэн Н26-28		“Тэнцэхгүй”
		Нудний булчин, хос харааны хөдөлгөөн, аккомодаци ба рефракцийн эмгэг		
